

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн
377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 1-р Хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	Ард Санхүүгийн Нэгдэл ХК
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар
Хурал хуралдах өдөр, цаг	2024 оны 4 сарын 27-ны өдөр, 11:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүргийн, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр, 17 давхар
Хурлын төрөл	Ээлжит
Хурал зарлагч	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2024 оны 3 сарын 15-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо	2024 оны 3 сарын 20-ны өдөр 2024 оны 4 сарын 9-ний өдөр
Бүртгэлийн өдөр	2024 оны 4 сарын 5-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2024 оны 3 сарын 25-ны өдөр
Хүргүүлсэн огноо	2024 оны 3 сарын 18-ны өдөр
Хурлын даргын нэр	Чулууны Ганхуяг
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс	Тооллогын комиссын дарга: О.Нандинцэцэг Тооллогын комиссын гишүүн: Ө.Бямбагэрэл, Т.Батбаяр
Баримт, бичгийн жагсаалт	Хавсралтаар
Баримт, бичгийн хуудасны тоо	

Хурал зохион байгуулах комиссын дарга

Ч.Ганхуяг

2024 оны 3 сарын 18-ны өдөр



.....

2024 он 03 сар 15 өдөр

Дугаар 24/03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 сарын 15-ны өдрийн эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2024 оны 4-р сарын 27-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүргийн, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр, 17 давхарт зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 сарын 5-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, хоёроос доошгүй өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 3 сарын 20-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2024 оны 4 сарын 9-ний өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 3 сарын 25-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
6. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 4 сарын 26-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
7. Хурлын даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуягийг томилсугай.
8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Золбоо

Санхүү эрхэлсэн захирал Х.Билгүүн

Дижитал стратеги эрхэлсэн захирал Ж.Дашням

ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Ө.Ашхүү

Маркетингийн ерөнхий менежер Б.Ганчимэг

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.
Үүнд:

Тооллогын комиссын дарга:

О.Нандинцэцэг (Ард Суппорт ХХК)

Тооллогын комиссын гишүүд:

Ө.Бямбагэрэл (Ард Секюритиз УЦК ХХК)

Т.Батбаяр (Ард Секюритиз УЦК ХХК)

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэл захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Золбоод даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 3 сарын 15-ны өдрийн
24/03 тоот тогтоолын 1-р хавсралт/



**2024 ОНЫ 4 САРЫН 27-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
3. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
4. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
5. ТУЗ-ийн төсвийг батлах (саналын хуудас);
6. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах (саналын хуудас).

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 3 сарын 15-ны өдрийн
24/03 тоот тогтоолын 2-р хавсралт/



**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ
ХУУДАС**
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ № 3, 5, 6)

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2024 оны 4-р сарын 27-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүргийн, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр, 17 давхарт хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.			
2	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг "хавсралт 1"-ийн дагуу баталсугай.			
3	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсугай.			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очин, хурлын материалтай танилцаж, санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичин, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
5. Саналыг саналын хуудсаар эсвэл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа

эзэмшигчийн

гарын

үсэг

Санал авах хуудсыг үйлдсэн 2024 оны ... -р сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____/...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 3 сарын 15-ны өдрийн
24/03 тоот тогтоолын 3-р хавсралт/



"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 сарын 15-ны өдрийн ... тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

Компанийн оноосон нэр: Ард Санхүүгийн Нэгдэл ХК (AARD)

Хурал хуралдуулах газар: Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүргийн, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр, 17 давхарт

Огноо: 2024 оны 4 сарын 27-ны өдрийн 11:00 цагт

Санал өгөх хэлбэр: Ард Апп (Ard App) болон цаасаар саналаа өгнө.

2024 оны 4 сарын 27-ны өдөр хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид урьдчилсан санал өгөх боломжтой. Саналыг Ард Секюритиз ҮЦК ХХК компанийн Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар хаягаар дамжуулан авах ба саналын хуудас хүлээн авах сүүлийн хугацааг 2024 оны 4 сарын 26-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгоно.

Хурлын хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
3. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
4. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
5. ТУЗ-ийн төсвийг батлах (саналын хуудас);
6. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах (саналын хуудас).

Бүртгэлийн өдөр: 2024 оны 4 сарын 5-ны өдөр

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;

4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2024 оны 3 сарын 25-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл www.ardholdings.com цахим хуудсаар зочлон хурлын материалтай танилцах боломжтой.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар

Утас: 7700 3322, 99588931

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 3 сарын 15-ны өдрийн
24/0.3 тоот тогтоолын 4-р хавсралт/



**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

2024 оны 4 сарын 27-ны өдөр

№24/01

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ (ТӨСӨЛ)

*Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.9 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

2024 оны 4 сарын 27-ны өдөр

№24/02

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ (ТӨСӨЛ)

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.13 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 4 сарын 27-ны өдрийн хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх болон Цалин, Урамшууллын хороонд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

_____ он _____ сар _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

2024 оны 4 сарын 27-ны өдөр

№24/03

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ (ТӨСӨЛ)

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.1, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулж хурлаар шийдвэрлэсэн холбогдох баримт бичгүүдийг зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэх, компанийн дүрмийг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Золбоод үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ